
 БАТЛАВ
 ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 С.ЭНХБАЯР
 2023 оны 07 дугаар сарын 24 өдөр

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГА БАРИХ АЖЛЫН
ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	- Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны 11 дүгээр тогтоол. - Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан 2023 оны МЗХ2023/16-007 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар.
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо одоогийн Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн эдэлбэр газарт.
3.	Зориулалт, хүчин чадал	- Тэнхлэгээрээ 10.0х20.0 м.кв, тагт, консоль, довжоо, рампыг нормоор тооцон эдэлбэр газарт багтаан төлөвлөх.
4.	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5.	Барилгын үндсэн бүтээц, материал	- Батлагдсан зураг төслийн дагуу. /Төслөөр шийдэх/
6.	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	- Загвар зураг шинээр боловсруулж баталгаажуулсны дараа нэгдсэн эмнэлгийн барилгын ачаалал тооцож хангагч байгууллагуудаас шинээр техникийн нөхцөлүүдийг гаргуулна. Тус техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах, техникийн нөхцөл олгогдохгүй тохиолдолд өөрийн эх үүсвэрээр инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, батлуулах.
7.	Зураг төслийн иж бүрдэл	<p><u>Баримт бичгийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none"> - Газрын гэрчилгээ, кадастрын зураг - Архитектур төлөвлөлтийн даалгавар - Инженер геологийн дүгнэлт - Байр зүйн дэвсгэр зураг /газар доорх болон дээрх шугам сүлжээний тодруулгын хамт/ - Техникийн нөхцөлүүд /УСУГ, УБДС, УБЦТС, МХС/ - Онцгой байдлын дүгнэлт - Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт - Магадлалын ерөнхий дүгнэлт /хавсралтын хамт/ - Барилгын хувийн хэрэг болон бусад холбогдох бичиг баримт <p><u>Ажлын зургийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none"> - Нүүр хуудас /батлагдсан/ - ЕТ- Ерөнхий төлөвлөгөө - БА- Барилга архитектур - ТХ-Технологийн зураглал - ББ- Барилга бүтээц - ХС- Халаалт, агаар салхивч - ЦБУ- Усан хангамж, ариутгах татуурга - ХТ, ДГ- Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг - ХД- Холбоо дохиолол - ГД- Гадна дулаан - УХАТ- Гадна усан хангамж, ариутгах татуурга - ГЦ – Гадна цахилгаан

		<ul style="list-style-type: none"> - ГХ – Гадна холбоо - Барилгын нэгдсэн төсөв /Тооцооны ESTIMATOR-PRO программ/ <p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> - Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх. - Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага: <ul style="list-style-type: none"> o Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх. o Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх.
8.	Төсөл боловсруулах үе шат	<p><u>Зураг төсөв боловсруулах</u></p> <ul style="list-style-type: none"> - Талбайн судалгаа хийх. - Эх загвар зураг шинээр боловсруулж, батлуулах. - Иж бүрэн ажлын зураг төсөв боловсруулж, зөвшилцөж, батлуулах. <p><u>Ажил гүйцэтгэх</u></p> <ul style="list-style-type: none"> - Батлагдсан иж бүрэн ажлын зураг төсвийн дагуу нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх.
9.	Төсөл боловсруулах байгууллага	<ul style="list-style-type: none"> - Барилга хот байгуулалтын яамны сайдын тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд.
10.	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none"> - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар. - Утас: +976-7777 1965
11.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан загвар зургийг үндэслэн шугам сүлжээний ачаалал тооцож хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлүүдийг гаргуулан ажлын зураг, төсвийг иж бүрэн боловсруулна. - Санал болгох үнийн дүнд шинээр хийгдэх зургийн үнэ, мөн гадна инженерийн шугам сүлжээний болон барилга угсралт, зөөж шилжүүлэх, нөхөн сэргээх, гадна тохижилт болон тухайн ажилтай холбоотой өртөг бүгд багтсан байна. - Олгогдсон техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, батлуулна. - Барилгын орц гарцыг гадна авто замтай болон явган замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх. - Борооны болон гадаргуугын ус зайлуулах шугамыг байгууламжийн өндөршилттэй уялдуулан норм дүрмийн дагуу төлөвлөх. - Инженерийн шугам, сүлжээ нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд буулгалт, зөөж шилжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг зураг, төсөвт тусгах. - Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг саадгүй түргэн аврагдах нөхцөлийг бүрдүүлэх. - Тус барилгын дотор засалд хэрэглэх материал нь хурц үнэргүй, эрүүл мэндэд хоргүй, норм дүрэм, стандарт, шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн сонгох. - Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төсвийг боловсруулах.

		<ul style="list-style-type: none"> - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбд 30.01.04/-ийн 6.39 хэсгийг онцгой анхаарч төлөвлөх. <p>Барилга байгууламж:</p> <ul style="list-style-type: none"> - Газар хөдлөлийн тэсвэршлийн тухайн байршилд хийгдсэн инженер геологийн дүгнэлтийг үндэслэнэ. - Эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал бага байх. - Барилгын онцлогийг архитектур орон зайн өвөрмөц шийдэлтэй байхаар тусгах. - Олон нийт иргэний барилгын норм дүрмийг хангах. - Өрөө тасалгаанд нарны гэрэл шууд тусахаар төлөвлөх. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, пандусыг норм дүрмийн дагуу төлөвлөх. - Барилгын аврах гарцыг нормын дагуу төлөвлөх ба саадгүй түргэн аврагдах гарцыг төлөвлөх. - Коридор хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай бариул төлөвлөх. - Барилгын гол ба туслах орц гарц, саравч довжоо зэргийг норм дүрмийн дагуу хийгдсэн байх.
12.	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<p>Ерөнхий төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Гадна тохижилтыг орчны барилга байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар төлөвлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц, пандусыг стандарт /MNS 6056:2009, 6055:2009/ болон норм дүрэм /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох норм БД 31-112-11/-н дагуу төлөвлөх. - Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын БНБД 21-01-02-г баримтлан зураг төслийн хийц архитектур төлөвлөлтийн шийдлийг бүрэн төлөвлөх. - Барилгад сэргээгдэх эрчим хүч ашиглах боломжтой эсэхийг судлах. - Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах. - Гадна явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх. - Барилга байгууламжийн орц, гарцыг төв авто замын хөдөлгөөн, явган зорчигчийн хөдөлгөөн давхцахгүй байхаар нягт уялдуулан төлөвлөх. - Ерөнхий төлөвлөгөөний элементийг цогцолбор барилгатай уялдуулан орчин үеийн шаардлагад нийцсэн байхаар төлөвлөх; /Барилгын гадна байх зарлалын самбар, гадна гэрэлтүүлэг, мод, зүг чиг/. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй үйлчилгээ авахаар төлөвлөх. - Ногоон байгууламжийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба шинээр төлөвлөх ногоон байгууламжийг төлөвлөлтийн бүсээс гадна нийтийн эзэмшлийн зам талбайтай уялдуулан төлөвлөх боломжийг судлан зурагт тусгах.
13.	Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Хууль тогтоомжууд:</p> <ul style="list-style-type: none"> - Газрын тухай хууль - Барилгын тухай хууль <p>Норм, нормативууд:</p> <ul style="list-style-type: none"> - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбд 30.01.04/ - Барилгын инженер геологийн ажил /БНбд 11-03-01/ - Барилгын геодезийн ажил /БНбд 11-08-06/ - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНбд 21-01-02/ - Барилга захиалагчийн дүрэм - Барилгын бүтээц ба суурийн найдваршил. Ерөнхий шаардлага /БНбд 20-01-11/

	<ul style="list-style-type: none">- Агааржуулалтын системийг олон нийтийн барилгын шаардлага орчинд нийцсэн дэвшилтэт технологийн шийдэл бүхий тоног төхөөрөмжтэй төлөвлөх.- Гал илрүүлэх болон унтраах зориулалттай автомат систем төлөвлөх.- Эрчим хүчинд хэмнэлттэй орчин үеийн шийдэл бүхий тоног төхөөрөмж төлөвлөх.- Ослын гэрэлтүүлгийг орц гарц, коридорт төлөвлөх.
--	--

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН О.МӨНГӨНШАГАЙ


БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Ц.ТУЛГА

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

ATA6940
9077.83

2023 оны 05 сарын 22 өдөр		Дугаар МЗХ2023/16-007	Улаанбаатар хот
1	Газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/97 дугаар тушаалаар, Хан-Уул дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Богдхан уулын Дархан цаазат газрын тусгай хамгаалалттай газар нутаг, Арцатын ам /17100/ бүсчлэлд, Арцатын аманд байршуулан 41149.0 м2 талбайг "Аялагч зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах" зориулалтаар ашиглахыг зөвшөөрсөн 0211951 дугаартай газар ашиглах эрхийн гэрчилгээг үндэслэв.	
2	Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг Эмнэлгийн өргөтгөлийн барилга	
3	Тэнхлэгээрээ	10.0x20.0м2, тагт, консоль, довжоо, рампыг нормоор тооцон эдэлбэр газарт багтаан төлөвлөх.	
4	Барилгын төрөл, давхрын тоо	Хийцлэлийг төслөөр	
5	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, бүс	Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөө, Дундаж давхрын орон сууцны бүс	
6	Эдэлбэр газрын талбай:	41149.0 м2	
	- Барилгажих талбай	200.0м2 /ХБТХууль 12.8/	
	- Ногоон байгууламж, гадна тохижилт төлөвлөх талбай	Эдэлбэр газрын 30%-аас доошгүй талбайд /ХБТХууль 12.6.3/	
	- Авто зогсоол	БНБД 30-01-04-н заавал мөрдөх 14 дүгээр хавсралтад зааснаар /ХБТХууль 12.6.3/, эдэлбэр газартаа багтаан газар доорх авто зогсоол төлөвлөх боломжтой	
7	- Хашаа, хайс	Эдэлбэр газарт багтаах, түр хашааны өндөр 3 метр, хамгаалалтын торны өндөр 2 метр, "Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах буулгах журам"-ын дагуу явган зам аюулгүй байдлын гарц хааж хашаа барихыг хориглоно. Барилгын зөвшөөрөл харагдах байдлыг самбараар үзүүлэх.	
	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага	Орчинтой уялдуулж ногоон байгууламж төлөвлөх, зам талбайд гэрэлтүүлэг хийх, хяналтын камер байрлуулах, явган хүний болон дугуйн зам, талбайг орчинтой уялдуулан тохижуулах, онцгой нөхцөлд ашиглах орц гарц төлөвлөх	
8	Архитектур төлөвлөлтийн шаардлага	Гадна тохижилтыг орчны барилга байгууламжуудт уялдуулан нэгдсэн байдлаар төлөвлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц, пандусыг стандарт /МН 6056:2009; 6055:2009/ болон норм дүрэм /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцс зураг төсөл зохиох норм БД 31-112-11/-н дагуу төлөвлө барилгын зураг төслийг хийц архитектур төлөвлөлтийн шийдлийг бүрэн гаргаж боловсруулах, барилгын гад гэрэлтүүлгийн шийдлийг тусгах, барилгад сэргээгдэх эрч хүч ашиглах боломжийг судлах, ногоон дээврийн шийдлийг тусгах, одоо байгаа болон төлөвлөгдсөн барилгуудын г тэсвэршилтийн зэргийг тооцож, шинээр төлөвлөж б барилгын гал тэсвэршилтийн зэргийг бууруулахгүй бу тохиромжтой хийцийг сонгон төлөвлөх.	
9	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл	"Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөө"-г баримтлан авто зам болон явган зам	

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАГЧ,
ҮСГЭЛИЙН ГАЗАР
Архитектур төлөвлөлтийн
шаардлага



НИЙСЛЭЛИЙН АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2023 оны 05 сарын 22 өдөр
ТХАЭБН н. 0117401


		талбай, ногоон байгууламжтай уялдуулан нэгдсэн төлөвлөлт боловсруулах, тус газартай хөрш залгаа газар, эд хөрөнгө эзэмшигчтэй зөвшилцөж загвар зураг боловсруулах. Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм /БНБД 22-04-16/ болон /MNS 6426:2013/ стандартын холбогдох заалтуудын дагуу төлөвлөх. Галын аюулгүйн норм /БНБД 21-01-02, БНБД 21-02-02/-ын дагуу онцгой байдлын үед гал унтраах, аврах баг бүрэлдэхүүн саадгүй ажиллах боломжийг хангаж төлөвлөх. Одоо байгаа барилгуудын хэвийн, аюулгүй байдлыг ханган барилгажуулах. Авто замын хамгаалах зурвас зай хэмжээ, аюулгүй байдлыг ханган, орц гарц гудамж зам саадгүй байхаар барилгажуулах.
10	Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага	Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгуудтай уялдуулж талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх
11	Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, норм дүрэм стандартыг баримтлан төлөвлөх /гадна шугам сүлжээний зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулах/, газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээ эзэмшигчидтэй зөвшилцөн шугам сүлжээг зөөж шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж, баталгаажуулсан тохиолдолд загвар зураг боловсруулах.
12	Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)	Барилга байгууламжийг төлөвлөхдөө тухайн газрын гадаргууд өндөржилтийн хэмжилт хийх, үер, хөрсний нурултаас хамгаалах бэхэлгээ, далан, суваг, гүүр, гарц, зам, талбай барьж байгуулах урьдчилсан арга хэмжээг тусгах, барилгын түр хашаанд зохих шаардлага тавих, барилгын зөвшөөрөл харагдах байдлыг самбараар үзүүлэх.
13	Барилгажилтын улаан шугам	Магадлал хийлгэсэн ажлын зургийн дагуу барилгын 0 тэнхлэг тавиулж, барилгын ажлыг эхлүүлэх
14	Захиалагчийн нэр, утас	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Аж ахуйн албаны дарга З.Отгонбаяр, Утас: 976-88108454

Анхааруулга:

1. Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
2. Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх
3. Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах, зөөх, засварлах, шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг архитектур төлөвлөлтийн даалгаварт хавсаргах.
4. Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа АТД-т заасан нэр, зориулалт, барилгын давхрын тоо, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд загвар зураг батлагдахгүй болно.
5. "Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, шаардлага" UCS 0901B:2020, UCS 0902B:2020, UCS 1603C:2020, UCS 1601B:2020, UCS 1601C:2020, UCS 0903B:2020, UCS 0001-01:2019, UCS 0001-02:2019, UCS 1602B:2020, UCS 1602C:2020, UCS 0002-02:2019, UCS 1901B:2020, UCS 1403C:2020, UCS 1404C:2020-г тус тус мөрдөх. /Тухайн ажлын хүрээнд тохирсон буюу авто зам, барилга, тохижилтын ажил, дугуйн зам тус бүрд нь холбогдох стандартуудыг тусгайлан сонгон авах/
6. Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсанаас хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд загвар зураг батлагдсанаар цаашид загвар зургийн хүчинтэй хугацаанд барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.


ХЯНАСАН

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  /Д.ХАН-УУЛ/

БОЛОВСРУУЛСАН

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН


ХОТ БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  /М.ОДОНТУНГАЛАГ/



БАРИЛГАЖИХ ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ

(Дугаар: МЗХ2023/16-007 архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	Эмнэлгийн өргөтгөлийн барилга



Масштаб 1:1:500

Тусгаа: EPSG:32648

(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)

ТАНИХ ТЭМДЭГ

- Одоо байгаа барилга
- Төлөвлөлтийн хязгаар
- Нэгж талбар
- Цэвэр усны шугам
- Бохирын шугам
- Дулааны шугам
- Холбооны шугам
- Үерийн шугам

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй байршил
2	Скайциркл ХХК
3	Одоо байгаа эмнэлгийн барилга
4	Зам дауух цэцэрлэгт хүрээлэн
5	Эдэлбэр газрын хил

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ

№	X	Y	тал=урт(м)
1	636958.313	5303275.999	1-2=20.000
2	636976.060	5303285.222	2-3=10.000
3	636971.448	5303294.095	3-4=20.000
4	636953.702	5303284.872	4-5=10.000
5	636958.313	5303275.999	5-1=0.000

ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эдэлбэр газар (м2)	39398.0
Барилгажих талбай (м2)	200.0



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
Барилга, хот байгуулалтын хэлтэс

Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын ам /17100/
Наадамчдын зам 1200
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn, www.ebarilga.ub.gov.mn
Утас: 11-324975